



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/91

Улаанбаатар хот

Хүүхдийн зуслангийн талаар авах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хөгжлийг дэмжих, чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, хүүхдийн зусланд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор "Зуслантай зун" арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Энэ тушаалыг хэрэгжүүлэх хүрээнд доор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох нэгж, байгууллагад үүрэг болгосугай:

2.1. "Зуслантай зун" арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллага, холбоотой хамтран зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар /Х.Тамир/-т;

2.2. Хүүхдийн зусланд хүүхдийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааны жишиг хөтөлбөр боловсруулж, ирүүлэхийг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн /Х.Отгонбаатар/-д.

2.3. Хүүхдийн зусланд хүүхдийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааны жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш, хүний нөөцийг чадавхжуулах, давтан сургах, багш мэргэжлээр болон сэтгэл зүй, нийгмийн ажил, эрүүл ахуйч мэргэжлээр суралцаж байгаа бакалаврын түвшний оюутны дадлагыг хүүхдийн зуслан түшиглэн зохион байгуулах асуудлыг судалж, хэрэгжүүлэхийг Боловсролын ерөнхий газар /Х.Тамир/-т;

2.4. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа, хөгжлийн хөтөлбөрийг таниулах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ зохион байгуулахыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт;

2.5. "Зуслантай зун" арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Л.Ганбат/-т;

3. Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд хамтрагч байгууллагуудын оролцоог хангаж, хүүхдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, онцгой байдлын бэлэн байдлыг хангах талаар анхаарч ажиллахыг Зуслангийн холбоонд зөвлөсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Т.Ням-Очир/-д даалгасугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

1425010001